



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны дүгээр сарын 09-ны өдрийн 09:00 дугаар албан бичгийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

2024 оны 09 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

Д/ Д	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Зарцуулсан төсөв (мян.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023 он	Зорилтот түвшин 2024 он	Хүрсэн түвшин (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэт- гэлийн хувь
	1	2	3	4	5	6	7

Стратеги төлөвлөгөөний зорилго 1.Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангана. СТ-1.1-1.4, НСТ-2.2, 2.3

Зорилт 1.1.иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.2.1		Улсын төсвөөс 16.340.0	Нэмэгдүүлсэн ажлын тоо	-	2	Нийслэлийн иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, туршлага солилцох, шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг нийтэд сурталчлах зорилгоор 1 сургалт, нийтийг хамарсан 1 арга хэмжээг шинээр санаачлан зохион байгуулсан.  2024 оны гуравдугаар улирлын байдлаар нийтийг хамарсан 13 арга хэмжээ зохион байгуулж 1670 байгууллагын 105.290 иргэнийг хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад зохион байгуулсан арга хэмжээ 3, хамрагдагсдын тоог 3 хувиар нэмэгдсэн байна.	90%
1.	1.1.1.Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод, ЕБС, цэцэрлэг, биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч, багш, арга зүйч, албан хаагчдад зориулсан сургалт, үйл	Улсын төсөв 12.790.0	Сургалтын тоо	5	6	Спортын төрлүүдийг хөгжүүлж, багш, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох зорилгоор Дүүргийн Биеийн тамир, спортын хороодын ажилтан, албан хаагчид, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш болон биеийн тамир, спортын хамтлагийн арга зүйч, шүүгчид, сайн дурын ажилтнуудад зориулсан 5 төрлийн сургалт зохион байгуулж 309 байгууллагын	90%

	ажиллагааг зохион байгуулна.					1480 багш, дасгалжуулагч, арга зүйчид, оюутнууд хамрагдсан.	
2.	1.1.2.Ахмад насын иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хамруулж дэмжлэг үзүүлнэ.	-	Хамрагдсан иргэдийн тоо	4800	4900	<p>Нийслэл, дүүргийн хэмжээнд 55-аас дээш насны ахмад иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор 2024 оны гуравдугаар улиралын байдлаар 33 арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулж 1227 байгууллагын 6286 хүнийг хамруулсан.</p> <p>Үүнд “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийн 1,5км, 5км, 10км, 21км, 42км-ийн зайд 213 байгууллагын 918, Монгол Улсад орчин үеийн биеийн тамир, спорт үүсэж хөгжсөний 100 жилийн ойн нэрэмжит ахмадын Софт теннисний тэмцээнд 40 байгууллагын 220 ахмад тамирчид оролцсон бол биеийн тамир, спортын хороодоос ахмадад зориулсан 31 уралдаан, тэмцээн зохион байгуулж 974 байгууллагын 5148 ахмадыг хамруулсан байна.</p>	100%
3.	1.1.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулж дэмжлэг үзүүлнэ.	Улсын төсөв 4.000.0	Оролцогчдын тоо	1700	1750	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр спорт заал, зориулалтын талбайг нээлттэй, үнэгүй ашиглуулах, секц дугуйланг шинээр байгуулах чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж зөвлөмж гарган дүүргийн Биеийн тамир, спортын хороодод 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 02/71 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Энэ хүрээнд 2024 оны гуравдугаар улирлын байдлаар Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Багануур, Багахангай, Налайх 6 дүүргийн биеийн тамир, спортын хороод ашиглалтыг нь хариуцаж байгаа 6 спорт цогцолбор, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүд нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа 3 спорт заал, 2 усан бассейнд үнэ төлбөргүйгээр 7 хоног бүр хуваарыт цаг гарган нийт 17 байгууллагын 239 иргэнд тогтолц үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа бол даам, хонхот бөмбөг, бочи, хэрэглэлтэй сэлэм, фитнес, суугаа волейбол, ширээний теннис, туялзуур сэлэм, тусгай олимпийн төрөл, парабадминтон гэсэн 10 төрлөөр секц, дугуйланг хичээллүүлж 19</p>	100%

						байгууллагын 150 иргэнийг тогтмол хичээллүүлж байна. Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд тэгш хамруулах чиглэл бүхий төлөвлөгөө гарган ажиллаж 2024 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 32 арга хэмжээ зохион байгуулж 254 байгууллагын 1750 иргэн хамрагдаад байна. Дээрх арга хэмжээнүүдэд нийт 29.158.600 төгрөгийг зарцуулсан.	
4.	1.1.4: Орон нутгийн нэр хүндтэй тамирчин, дасгалжуулагчдаар ёс зүй, зөв хандлага төлөвшүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгох талаар нийгэмд зөв зүйтэй үлгэр дуурайлал болох нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	20	21	Спортоор дамжуулан нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг сайжруулах зорилгоор 2024 оны гуравдугаар улиралд 14 арга хэмжээ, уралдаан тэмцээнд буюу "Улаанбаатар марафон 2024" олон улсын гүйлтэд Монголын үндэсний шигшээ багийн тамирчин Г.Хишигсайхан, Б.Мөнхзаяа, Улаанбаатар хотын аварга шалгаруулах Жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын гавьяат тамирчин Х.Цагаанбаатар, Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан сургалтад зумба фитнесс олон улсын багш, дасгалжуулагч Θ.Долгормаа, Хан-Уул дүүргийн аварга шалгаруулах Жүдо бөхийн тэмцээнд Казахстан, Монгол Улсын гавьяат тамирчин Д.Төмөрхүлэг, Хан-Уул дүүргийн аварга шалгаруулах "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн тэмцээнд "Хасын хүлгүүд" багийн довтлогч, сагсан бөмбөгийн спортын мастер О.Сэргэлэн, Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах Чөлөөт бөхийн тэмцээнд Монголын гавьяат тамирчин С.Батцэцэг, СБД-ийн Эрүүл монгол хөтөлбөрийн өдөрлөг, Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах Хүндийг өргөлтийн тэмцээнд МУГТ хүндийн өргөлтийн тамирчин М.Анхцэцэг, Сонгинохайрхан дүүргийн аварга шалгаруулах Дугуйн тэмцээнд дугуйн спортын мастер М.Мөнхбат, Улаанбаатар Сөүл хотуудын жүдо бөхийн тамирчдын нөхөрсөг багийн тэмцээнд, Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын гавьяат тамирчин Х.Цагаанбаатар, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч М.Бундмаа, Хан-Уул дүүргийн	70%

							үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээнд Улсын начин Э.Батмагнай, Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах боксын тэмцээнд, боксын спортын мастер С.Уянга, БГД-ийн Иргэдийн спортын наадмын волейболын тэмцээнд Волейболын Олон улсын хэмжээний мастер Э.Энхдэлгэр, нарыг оролцуулж хувь хүний ёс зүй, зөв хандлага, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх ажлуудыг зохион байгуулсан.	
	Зорилт 1.2.Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.2.1,	-	Байгууллагын тоо	9	9	Биеийн тамир, спортын салбарын жишиг бүтцийн дагуу нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороод 2024 оны гурвдугаар дугаар улирлын байдлаар 208 ажилтан, албан хаагч үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан 98 мэргэжилтэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулах журам"-ын дагуу 2024 оны 05 дугаар сард зохион байгуулж Хан-Уул, Сонгинохайрхан, Багахангай, Налайх, Сүхбаатар дүүргийн дарга нар жинхлэгдсэн. Тусгай шалгалт зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд орж ажилласан.	85%	
5.	1.2.1.Биеийн тамир, спортын хамтлагийн тоог нэмэгдүүлж үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	-	Хамтлагийн тоо	808	815	2024 оны гуравдугаар улирлын байдлаар нийслэлийн хэмжээнд 6 (БХД-ийн Ус суваг ашиглалтын товчоо, БХД-ийн тохижилт, БХД-ийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, ХУД-ийн Мишээл, ХУД-ийн 326 дугаар цэцэрлэг, 322 дугаар цэцэрлэг) хамтлаг шинээр байгуулагдаж нийт 816 биеийн тамир, спортын хамтлаг үйл ажиллагаа явуулж байна. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийтэд таниулах, урамшуулах зорилгоор 6 хамтлагийг "Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын хамтлаг"-аар шалгаруулсан өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан бол хамтлагийн үйл ажиллагаанд тулгуурлан "Улаанбаатар марафонд	100%	

						нэгдэцгээ" цомын аяныг Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн хэмжээнд аялуулж, 123 удаагийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, өдөрлөг зохион байгуулж, 316 байгууллагын 63140 албан хаагчийг хамруулсан.	
6.	1.2.2.Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж нэгдсэн мэдээллийн санд оруулна.	-	Бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	57.5% (A, B, C үнэлгээ авсан байна)	60% (A, B, C үнэлгээ авсан байна)	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж 2024 оны гуравдугаар улирлын байдлаар 483 байгууллагын 58575 иргэн хамрагдаж, чанарын үзүүлэлтийг <a href="http://www.cpanel.sport.gov.mn">www.cpanel.sport.gov.mn</a> сайтад шивж оруулж байна. Одоогоор үр дүн баталгаажих хугацаа болоогүй байна.	70%
	Зорилт 1.3.Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх НХТЖҮЧ-3.5.4, НЗДҮАХ-2.2.2, НХТ-53	-	Хэрэгжилтийн хувь	-	100%	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2024 оны гуравдугаар урилалд 27 спортын холбоотой ажил гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ байгуулж 129.070.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг спортын 17 төрлөөр, даншиг наадам 2 төрөл, нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулж 206 байгууллагын 4698 тамирчид оролцсон. Гадаад арга хэмжээний төлөвлөгөөг 9 ажил, арга хэмжээтэй баталж хэрэгжилт 100 хувьтай байна.	65%
7.	1.3.1.Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна.	-	Хамрагдсан багш, дасгалжуулагчдын тоо	50	100	Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчдыг чадавхжуулах зорилгоор Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороотой хамтран волейболын онол, практик хосолсон сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж 16 байгууллагын 110 багш, дасгалжуулагчид оролцсон.	100%
8.	1.3.2.Олимпын эрхийн оноо олгох олон улсын жудо бөхийн "Улаанбаатар их дуулга"	-	Оролцогч орны тоо	44	44	Олимпын эрхийн оноо олгох олон улсын Жүдо бөхийн "Улаанбаатар их дуулга" тэмцээнийг 2024 оны 06 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн ч тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.	30%

	тэмцээнийг зохион байгуулна.						
	Зорилт 1.4. Гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх.	-	Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл	6	9	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд 9 ажил үйлчилгээг гүйцэтгэхээр төлөвлөснөөс гуравдугаар улирлын байдлаар нийт 13 ажил гүйцэтгэнээс төлөвлөгөөнд туссан 9-н ажил, нэмэлтээр 4-н ажлыг гүйцэтгэсэн.	100%
9.	1.4.1.Aх дүү хотуудын спортын байгууллагуудтай туршлага солилцож, олон улсын тэмцээн, уулзалт, арга хэмжээг зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	5	5	<p>Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гуравдугаар улирлын байдлаар төлөвлөгөөнд туссан 9, нэмэлтээр 4 ажил гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. БНСУ-ын Жүдо бөхийн холбооны Их хуралд байгууллагын дарга Ж.Ганболд оролцож “Монгол Улсын хэмжээнд Жүдо бөхийн хөгжил, тулгамдаж буй асуудал”-ын талаар илтгэл тавьсан.</li> <li>2. “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээний ахлах насны охид, хөвгүүдийн багуудаас түрүүлсэн 1, 1 баг ОХУ-ын Москва хотноо болох “КЭС-БАСКЕТ” олон улсын Супер цомын тэмцээнд оролцох эрхийг олгосон.</li> <li>3. БНХАУ-ын Бээжин хотын спортын их сургуулийн “Биеийн тамир, спортын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт”-д Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан хамрагдаж туршлага судлан сертификат гардан авсан.</li> <li>4. “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтэд 42 орны 341 гүйгч, үүнээс 4 улсын 12 тамирчин (Кени улсаас-2, ОХУ-аас-5, Япон улсаас-2, Франц улсаас-1, Герман улсаас-1, Англи улсаас-1) урилгаар оролцсон.</li> <li>5. “Улаанбаатар дэлхийн их дуулга” 3x3 сагсан бөмбөгийн мэргэжлийн тэмцээнд 12 баг өрсөлдсөн.</li> <li>6. “Улаанбаатар Урбан фестиваль” сагсан бөмбөгийн 3x3 олон улсын тэмцээнд 15 орны 15 багийн 200 орчим тамирчин, албаны хүмүүс оролцсон.</li> <li>7. Сун Хюнг Мин олон улсын хүүхэд залуусын найрамдалт хөлбөмбөгийн тэмцээнд өсвөрийн баг тамирчид оролцсон.</li> </ol>	100%

<p>8. АНУ-ын Кливлэнд хотноо болсон “Пан-Американ 2024” мастеруудын спорт наадмын 3х3 сагсан бөмбөгийн тэмцээний 50+ эмэгтэйчүүдийн ангилалд Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг багийн ахлагчаар оролцож багаараа алтан медаль хүртсэн.</p> <p>9. Улаанбаатар хотноо болсон Олон улсын хүүхдийн спортын Х наадамд 3-н улсын нийт 460 тамирчин спортын 9-н төрөлд өрсөлдөж Монгол Улсын баг 101 медалиар тэргүүлсэн.</p> <p>10. Улаанбаатар хотноо болсон "Олон улсын сургач солилцооны хөтөлбөр"-т оролцсон 5 улсын 5 хотын 70 сургачдын дунд "Бэсрэг наадам" зохион байгуулсан.</p> <p>11. Япон улсын Токио хотноо болсон “Өсвөрийн хүүхдүүдийн спорт солилцооны наадам”-д бадминтон, пара бадминтон, ширээний тенис, пара ширээний тенисний төрлүүдэд 23 хүний бүрэлдэхүүнтэй баг, тамирчид оролцож, ширээний тенисний баг тамирчид 7-р байранд шалгарсан.</p> <p>12. ОХУ-ын Москва хотноо болсон олон улсын Супер цомын тэмцээнд “Ирээдүй” сургуулийн охид, хөвгүүдийн баг оролцож Д.Лхагваа дасгалжуулагчтай хөвгүүдийн баг хүрэл медаль, охидын баг 5-р байрт шалгарсан.</p> <p>13. БНСУ-ын Жudo бөхийн холбооны 15 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг хүлээн авч, жudo бөхийн багийн нөхөрсөг тэмцээн зохион байгуулсан.</p>							
<p>Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2. Нийслэлийн иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшнийг дээшлүүлж, спортын төрлүүдийг хөгжүүлж, орчин нөхцөлийг сайжруулна. НХТЖҮЧ-3.5, НЗДҮАХ-2.2, НХТ-51</p>							
Зорилт хэвшлийн сууринсан оновчтой	2.1.Төр хувийн түншлэлд удирдлагын тогтолцоог бий	Улсын төсвөөс 73.473.000	Зохион байгуулсан	Нийтийн биеийн тамирын арга	Нийтийн биеийн тамирын арга	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжиж 2024 оны гуравдугаар улиралд 27 спортын холбоотой ажил гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ байгуулж 129.070.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг спортын 17 төрлөөр, даншиг наадам 2 төрөл, нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг	

богож, иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.2.1, НХТ-50, 51, 52	Нийслэлийн төсвөөс 751.274.70 4	арга хэмжээ, уралдаан тэмцээний тоо	хэмжээ 24, Спортын уралдаан тэмцээн 30	хэмжээ 15, Спортын уралдаан тэмцээн 23	зохион байгуулж 206 байгууллагын 4698 тамирчид оролцсон. Биеийн тамир, спортын хамтлагын дунд 123 удаагийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, өдөрлөг зохион байгуулж, 316 байгууллагын 63140 албан хаагчийг хамруулсан.	84%
10. 2.1.1.Дүүргийн Биеийн тамир, спортын хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчилж албан хаагчдын тоог шаардлагатай хэмжээнд нэмэгдүүлнэ.	-	Ажилтан, албан хаагчдын тоо	187	207	Биеийн тамир, спортын салбарын жишиг бүтцийн дагуу дүүргийн биеийн тамир, спортын хороод 2024 оны таравдугаар улирлын байдлаар 208 ажилтан, албан хаагч үүнээс биеийн тамирын асуудал хариуцсан 98 мэргэжилтэн ажиллаж байна.	100%
11. 2.1.2.Дүүргийн хороодыг орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болгох асуудлыг шийдвэрлүүлж хэрэгжүүлнэ.	-	Арга зүйчдийн тоо	-	17	Анхан шатны нэгжид биеийн тамир, спортын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах санал боловсруулан Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороонд 2023 оны 3/225, Биеийн тамир, спортын Улсын хороонд 2021 оны 2/73, 2023 оны 3/225, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэст 2022 оны 3/235 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж дэмжүүлснээр 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Улсын Их хурлын хаврын чуулганаар батлагдсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “сум, хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллаж биеийн тамир, спортын хуулийг хэрэгжүүлж орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ” нэршлээр орж батлагдсан.	90%
2.1.3.Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг	-	Болзол хангасан клубийн тоо	13	28	Спорт клубууд магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагдах, магадлан итгэмжлэгдсэн клубуудэд хичээллэж буй иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал авах эрх зүйн орчин 2019 оноос үйлчилж 2021 оноос түр зогссон. Спорт клубуудыг магадлач итгэмжлэлд хамрагдах	

12.	чанаржуулах зорилгоор магадлан итгэмжлэлийн болзол хангасан спортын клубийн тоог нэмэгдүүлнэ.					зөвшөөрлийг Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хорооноос олгоно. Стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллах, магадлан итгэмжлэгдсэн спорт клубүүдээр хичээллэх иргэд нийгмийн даатгалын сангаас урамшуулал авах эрх зүйн орчин бүрдсэний дараа нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод хамруулах ажлыг зохион байгуулна.	70%
13.	2.1.4.Нийтийг хамарсан биеийн тамирын томоохон (Улаанбаатар марафон, Иргэдийн спортын наадам, Нутгийн захиргааны наадам, “Дугуйн өдөр” өдөрлөг, “Алхацаа гүйцгээ” хөдөлгөөн гэх мэт) 15 арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсвөөс 40.510.000 Нийслэлийн төсвөөс 952.788.00 0	Хамрагдсан иргэдийн тоо	441,308	450,196	Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 оны гуравдугаар улиралд нийтийг хамарсан 13 (сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, уран хөдөлгөөнт гимнастик, софт, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, “Улаанбаатар марафон-2024”, “Алхацаа гүйцгээ” хөдөлгөөн, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ, “Даншиг наадам-хүрээ цам” наадам, Нүүдэлчин, Спорт явган аяллын шигшээ тэмцээн, Автомашингүй өдөр арга хэмжээ зохион байгуулж 1675 байгууллага, 304.486 иргэнийг хамруулсан.	70%
14.	2.1.5.Өвлийн спортын төрлүүд (Тэшүүр, гүйлтийн цана, уулын цана, мөсний сур, снөубоард, хоккей, мөсөн хананы авиалт	-	Хамрагдсан иргэдийн тоо	413,000	414,000	Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр 2024 оны гуравдугаар дугаар улирлын байдлаар 388.478 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Үүнд: Нийслэлийн 9 дүүрэгт өвлийн спортын нийтийг хамарсан 10 арга хэмжээ зохион байгуулж 25.909 иргэнийг хамруулсан.Өвлийн спортын төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг 7 удаа зохион байгуулж 693 тамирчин оролцсон. Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорт-трейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдсан. Монголын Тэшүүр, Хоккейн холбооны дэргэдэх бүртгэлтэй дугуйлан, секцэд 175 хүүхэд спортын 3(тэшүүр,	90%

	гэх мэт)-ийг хөгжүүлж иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэн, оролцоог нэмэгдүүлнэ.					хоккей, уран гулгалт) төрөлд хамрагдаж байна. Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 06 дугаар сарын 07-ны хооронд 103.062 иргэн үйлчлүүлсэн байна. Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэг дэх Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 153.000 иргэн үйлчлүүлсэн. Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 105.544 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.	
	Зорилт-2.2. Нийслэлд Үндэсний спорт болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг бэлтгэнэ. НХТЖҮЧ-3.5.4, 3.5.5, НЗДҮАХ-2.2, НХТ-57, 58, 59	Улсын төсвөөс 14.968.000 Нийслэлийн төсвөөс 170.663.5	Өсвөрийн шигшээ багийн хичээллэж буй спортын төрлийн тоо	26	26	Спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Улаанбаатар хотын аварга шалгаруулах 17 төрлөөр, даншиг наадам 2 төрөл, нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулж 206 байгууллагын 4698 тамирчид оролцсон. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 95 багт 95 дасгалжуулагчтай 2891 тамирчыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна.	97%
15.	2.2.1.Багийн спортыг дэмжих чиглэлээр өсвөрийн хүүхэд багачуудын дунд “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээн, нийтийн хөл бөмбөгийн фестиваль, “Мөрөөдлийн гол” хөл бөмбөгийн фестивалийг зохион байгуулна.	Нийслэлийн төсвөөс 170.663.5	Оролцогчдын тоо	145,200	145,250	Багийн спортын төрлөөр дамжуулан өсвөр үеийн хүүхэд, багачуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, хамтаж үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор 2024 оны гуравдугаар улирлын байдлаар “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейбол, “Улаанбаатар цом”, “Мөрөөдлийн гол” хөлбөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулж 158,746 тамирчин, иргэд, хүүхэд, багачуудыг хамруулсан. “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг бага, дунд, ахлах насны ангиллаар 5 үе шаттай амжилттай зохион байгуулж 9 дүүргийн ерөнхий боловсролын 192 сургуулийн охид, хөвгүүдийн 8208 багийн 90550 мянга гаруй сурагч оролцсон. “Улаанбаатар лиг” волейболын тэмцээнийг 2 насны ангиллаар 3 үе шаттай зохион байгуулж 9 дүүргийн ерөнхий боловсролын 141 сургуулийн 520 багийн 67098 сурагчид оролцсон. Нийслэлийн иргэдийн дунд “Улаанбаатар цом” хөл бөмбөгийн тэмцээнийг Монголын хөл бөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулж 7 дүүргийн 98 тамирчид оролцсон. Нийслэлийн ерөнхий боловсролын	100%

						сургуулийн сурагчдын дунд “Мөрөөдлийн гоол” хөлбөмбөгийн тэмцээнийг Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран зохион байгуулж 66 багийн 1000 гаруй хүүхэд, багачууд хамрагдсан.	
16.	2.2.2. Спортын холбоодтой 2024 онд гэрээ байгуулан Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 23 төрлөөр зохион байгуулна.	Улсын төсвөөс 14.968.000	Тамирчдын тоо	7,888	7,888	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2024 оны гуравдугаар улиралд 27 спортын холбоотой ажил гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ байгуулж 129.070.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 17 төрлөөр, даншиг наадам 2 төрөл, нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулж 206 байгууллагын 4698 тамирчид оролцсон.	90%
17.	2.2.3.Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн төрлийг нэмэгдүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	-	Спортын төрлийн тоо	26 төрөл	26 төрөл	Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 95 багт 95 дасгалжуулагчтай 2891 тамирчыг бэлтгэл сургуултад хамруулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2024 оны гуравдугаар улиралд тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит 333 удаагийн тэмцээнд оролцож 1763 медаль авсан амжилт үзүүлсэн бол Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 271.611.241(хоёр зуун далан нэгэн сая зургаан зуун арван нэгэн мянга хоёр зуун дөчин нэгэн) төгрөгийг зарцуулсан байна.	100%
	Зорилт-2.3.Биеийн тамир, спортын зориулалтын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5.2, НЗДҮАХ-2.2.3, НХТ-54, 55, 56	-	Спортын барилга байгууламжийн хүртээмж (м2)	63,5	64	Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй спортын заалтай барилга байгууламжийн судалгааг нэгтгэн гаргаж спортын барилга байгууламжийн хүртээмж 1000 хүнд 63,5мкв-д хүрснийг тодорхойлж гаргалаа.	82%
						Баянзүрх, Багахангай, Налайх дүүргийн спорт цогцолборын барилгын явцад хяналт тавьж биелэлтийг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан	

	2.3.1.Багахангай дүүргийн спорт цогцолборын ажлыг үргэлжлүүлж, Налайх, Баянзүрх дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулна.	-	Гүйцэтгэлийн хувь	82	90	заалт тус бүрээр гаргаж дээд шатны байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна. Баянзүрх дүүргийн спортын ордны бүтээн байгуулалтын ажил 85 хувьтай 2024 онд 2.58 тэрбум төгрөг тусгаж үерийн далангийн ажил хийгдэж байна. Багахангай дүүргийн Засаг даргын 2019 оны А/193 дугаар захирамжаар тус дүүргийн 2-р хороонд спорт цогцолбор барих зориулалтаар 1000 м2 газар олгогдсон. Тус спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр 2022 онд "Алтан шар.gov" ХХК шалгарч улсын төсвөөс 2022 онд 500.0 сая, 2023 онд 815.6 сая, 2024 онд 1.100.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлын 70 хувийг гүйцэтгэсэн. Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй Спорт цогцолборын барилгын ажлыг "Бүрд констракшн" улсын төсвөөс 15.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 2012-2024 оны 08 дугаар сард 100% гүйцэтгэсэн бөгөөд улсын комиссын дүгнэлт 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөр гарсан тул өмчид бүртгэн авах, Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороонд ашиглалтыг хариуцуулах ажлууд хийгдэж байна. Нийслэл хотод улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй спортын цогцолборуудын явцтай танилцсан хяналт тавьж зөвлөн туслах ажлын танилцуулгыг бэлтгэн хамтран ажиллах саналыг Хотын стандарт, хяналтын газарт албан бичгээр хүргүүлж санал солилцсон.	90%
19.	2.3.2.Баянхшуу дэд төвийн спортын цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэх ажлыг холбогдо байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	-	Гүйцэтгэлийн хувь	65	100	Баянхшуу дэд төвийн 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгч "Стандарт холдинг" ХХК, "Би энд Би" констракшн, "Таны зам" ХХК-ны үйл ажиллагааны явцтай улирал бүр танилцаж зураг, төсвийн дагуу, стандартыг хэрэгжүүлж ажиллахад хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд спорт цогцолборын агаар сэлгэлтийн технологийг стандартын дагуу зөв хийх талаар захиалагч, гүйцэтгэгч, хяналт тавьж байгаа байгууллагуудтай 2024 оны 06 дугаар сарын 02, 08 дугаар сарын 28-ны өдөр тус бүр уулзалт зохион байгуулж асуудлыг шийдвэрлэж ажилласан. Спорт	70%

						цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 75%-д хүрсэн байна.	
20.	2.3.3.Биеийн тамир, спортын талбайн бүтээн байгуулалт, тохижилтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	-	Бүтээн байгуулсан, тохижуулсан талбайн тоо	-	1	2023 онд Сонгинохайрхан дүүргийн 40-р хорооны спорт талбайг сэргээн засах ажлыг “Стандарт холдинг” ХХК эхлүүлж хуучин байгууламжийг нураах ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэхүү бүтээн байгуулалтын ажлыг 2024 оны эхний хагаст үргэлжлүүлж 15 хувийг гүйцэтгээд байна. Мөн Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороонд байрлах 5,0 тэр бум төгрөгийн улсын хөрөнгө оруулалтаар байгуулагдах хөл бөмбөгийн талбайн газар чөлөөлөлтийн ажил 2023 онд бүрэн дуусаж гүйцэтгэгчээр шалгарсан “Аглуут” ХХК нь тус бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж 2024 оны гуравдугаар улирлын байдлаар 40 хувийг хийж гүйцэтгээд байна. Мөн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хариуцан нийслэлийн нутаг дэвсгэрийн 2024 онд 20 байршилд 3x3 сагсан бөмбөгийн талбайг байгуулах ажил 95 хувьтай хэрэгжиж байна.	90%
21.	2.3.4.Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спортын талбайг стандартын дагуу тохижуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	-	Тохижуулсан талбайн тоо	2	2	Нийслэлийн ЕБС-иудын биеийн тамир, спортын гадна талбайн судалгаанд үндэслэн 2021 онд ЧД-ийн 24, 2022 онд СБД-ийн 2, ХУД-ийн 34, 52, 2023 онд ЧД-ийн 57, СХД-ийн 67 дугаар сургуулийн гадна талбайг дүүргийн ЗДТГ-н санхүүжилтийг шийдвэрлүүлж суурийн ажлыг гүйцэтгэн, Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ОУ-ын стандарт шаардлага хангасан хөлбөмбөгийн талбайг тохижуулсан. Монголын Хөл бөмбөгийн холбооноос 2024 онд Баянгол дүүргийн Оюуны ундраа цогцолбор сургуулийн гадна талбайг үерийн далан байгуулах ажлыг хийсний дараа хөл бөмбөгийн стандарт хиймэл зүлгээр шинэчилж тохижуулахаар хүлээгдэж байна. Хөл бөмбөгийн талбайн стандарт хиймэл зүлгийг захиалж ирүүлээд байна.	90%
	2.3.5.2024 оныг “Тохижилт-бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан нийслэлд	-	Спортын барилга байгууламжийн хүртээмж (м2)	63,5	64	2024 оныг “Тохижилт, бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл хотод улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 7 спортын цогцолборын явцад хяналт тавьж, зөвлөн туслах ажлын танилцуулгыг бэлтгэн хамтран	

22.	спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.					ажиллах саналыг Хотын стандарт, хяналтын газарт албан бичгээр хүргүүлж хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй Спорт цогцолборын барилгын ажлыг “Бүрд констракшн” улсын төсвөөс 15.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 2012-2024 оны 08 дугаар сард 100% гүйцэтгэсэн бөгөөд улсын комиссын дүгнэлт 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөр гарсан тул өмчид бүртгэн авах, Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороонд ашиглалтыг хариуцуулах ажлууд хийгдэж байна. Баянхошуу дэд төвийн 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгч “Стандарт холдинг” ХХК, “Би энд Би” констракшн, “Таны зам” ХХК-ны үйл ажиллагааны явцтай улирал бүр танилцаж зураг, төсвийн дагуу, стандартыг хэрэгжүүлж ажиллахад хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд спорт цогцолборын агаар сэлгэлтийн технологийг стандартын дагуу зөв хийх талаар захиалагч, гүйцэтгэгч, хяналт тавьж байгаа байгууллагуудтай уулзалт зохион байгуулж асуудлыг шийдвэрлэж ажилласан. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй спортын заалтай барилга байгууламжийн судалгааг нэгтгэн гаргаж спортын барилга байгууламжийн хүртээмж 1000 хүнд 63,5м2-д хүрснийг тодорхойлж гаргасан.	70%
Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт		-	Хэрэгжилтийн хувь	100	100	Биеийн тамир, спортын тухай хууль, Ерөнхийлөгчийн 4(53, 27, 144, 43) зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 3(183, 204, 147) тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, 2006 оны 1(A/165), 2015 оны 1(A/118), 2024 оны эхний хагас жилд шинээр 10(A/59, A/220, A/221, A/241, A/453, A/460, A/483, A/546, A/574, A/616), A/1048, A/1059 захирамж гарсныг хяналтад авч арга хэмжээ, уралдаан тэмцээнүүд бүрэн зохион байгуулагдаж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг нэгтгэн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.	88%
						2024 оны гуравдугаар улирлын байдлаар бодлогын 3 баримт бичиг, терөөс хэрэгжүүлж буй 3 төсөл арга	

23.	3.1. Улс, нийслэлийн дунд, богино хугацааны бодлогын бичгүүд болон бусад холбогдох баримт бичгүүдэд санал боловсруулж хүргүүлж ажиллана.	-	Санал өгсөн баримт бичгүүдийн тоо	11	12	<p>хэмжээ, байгууллагуудаас ирүүлсэн 3 төлөвлөгөө, нэг журам нийт 10 удаа санал боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт;</li> <li>✓ Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө;</li> <li>✓ Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах нь" журмын төсөлд санал</li> <li>✓ Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө;</li> <li>✓ Нийслэлийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;</li> <li>✓ "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөл"-ийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;</li> <li>✓ "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТУГ-т Хан-Уул дүүргийн 8, 21, 23, 24-р хороодыг хамарсан 1535 га талбайд "27-р нэгж хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголд;</li> <li>✓ Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд гарч байгаа анхан шатны суурь мэдээллийг нэгтгэн гаргаж, салбарын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого төлөвлөлтийг тодорхойлж;</li> <li>✓ Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар 2024 онд хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад санал өгсөн</li> <li>✓ Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойг угтан зохион байгуулах "Автомашингүй өдөр"-ийн арга хэмжээний төлөвлөгөөнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас "Спортлог Улаанбаатар" өдөрлөгийг тусган хэрэгжүүлэх саналыг шаардагдах төсвийн төслийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст тус тус хүргүүлсэн.</li> </ul>	90%	

24.	3.2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.	-	Тайлан мэдээний хугацаа	Хугацаа хэтэрч явуулсан тайлан мэдээний тоо 5	Хугацаа хэтэрч явуулсан тайлан мэдээний тоо 0	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2024 онд 3 чиглэлийн 29 тайлан, мэдээг давхардсан тоогоор 107 удаа гаргахаар хуваарийг баталсан. Хуваарийн дагуу тайлан, мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүд, дотоод удирдлагын нэгдсэн программ ERP-н Хяналт шинжилгээ, үнэлгээ дэд системд оруулж ажилласан бөгөөд хугацаа хэтэрч явуулсан тайлан, мэдээ гараагүй байна. 2024 оны гуравдугаар улирлын тайлан, мэдээг гаргаж хугацаанд нь тайлagnan ажиллаж байна.	90%
25.	3.3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөгөөнд манай байгууллагад хариуцуулан тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн тайлангийн тоо	10	10	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний 14 ажил бүхий төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж 2024 оны гуравдугаар улирлын байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, захирагааны байгууллагын үйл ажиллагааны 12 /давхардсан тоогоор/ тайлан, мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөн явцын хяналт хийсэн 4 байна.	90%
26.	3.4.Байгууллагын албан хаагчдын шилжилт хөдөлгөөний мэдээг төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системд оруулна.	-	Шинэчилсэн мэдээллийн тоо	2	2	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84, 128 дугаар тогтоолоор албан хаагчдын цалин хөлс, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 8 удаа давхардсан тоогоор 20 албан хаагчийн мэдээллийг төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын систем”-д шинэчилж оруулсан.	100%
27.	3.5.Биеийн тамир, спортын салбарын байгууллагуудын статистик судалгааны дүн мэдээг нэгтгэн цахим программд оруулна.	-	Цахим програмд оруулсан мэдээний тоо	7	7	Биеийн тамир, спортын төрийн байгууллагын үйл ажиллагааны 2023 оны 7 төрлийн мэдээг Үндэсний Статистикийн газрын 3-БТС-1, А-БТС-6, А-БТС-7 маягтын дагуу бэлтгэн <a href="https://cpanel.sport.gov.mn/">https://cpanel.sport.gov.mn/</a> программд оруулж pdf хэлбэрээр 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Засгийн газрын Тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хорооны <a href="mailto:www.info@sport.gov.mn">www.info@sport.gov.mn</a> албан ёсны цахим хаягаар хүргүүлсэн.	100%

28.	3.6. Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тайлагнах, ХАСХОМ гаргах албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Албан хаагчдын тоо	10	10	Нийслэлийн хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг нэгтгэж 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр байгууллагын даргаар баттуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлагын тасагт 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны гуравдугаар улирлын биелэлт 96.5 хувьтай хэрэгжиж, тайланг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 02/199 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг тайлагнах чиглэлээр Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 16 хаагчийг хамруулж байгууллагын 10 албан хаагчид хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг гарган баталгаажуулж цаасан хэлбэрээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлагын тасагт 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 3/62 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2024 оны гуравдугаар улирлын байдлаар Хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлэгт нь их хэмжээний өөрчлөлт орсон албан хаагч байхгүй болно. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Нягтлан бодогч, Эрх зүй, тогтоол шийдвэр, хариуцсан мэргэжилтэн, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн Спортын тэмцээн наадам, спорт холбоодын асуудал хариуцсан мэргэжилтний сул, орон тооны албан тушаалуудад шилжин, сэлгэн ажиллахаар нэр дэвшсэн 3 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 02/194 дугаар албан бичгээр хүргүүлж ажиллаа.	100%

29.	3.7.Нийслэлийн 2024 оны төсөвт батлагдсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнана.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын байр ашиглалтын зардалд 2024 онд 7,200,000(долоон сая хоёр зуун мянган) төгрөг батлагдсан бөгөөд 2024 оны гуравдугаар дугаар улиралд 3,648,000(гурван сая зургаан зуун дөчин найман мянган) төгрөгийн санхүүжилт авч бүрэн зарцуулан, өр авлага үүсгэлгүй ажиллаж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь хүргүүлж ажилласан.	90%
30.	3.8.Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	2024 оны гуравдугаар улирлын байдлаар биеийн тамир, спортын чиглэлээр гарсан шүүхийн маргаан байхгүй байна.	90%
31.	3.9.Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал чиглэлээр боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн саналын тоо	1	1	Дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах санал боловсруулан холбогдох байгууллагуудаар дэмжүүлснээр 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Улсын Их хурлын хаврын чуулганаар батлагдсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “сум, хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллаж биеийн тамир, спортын хуулийг хэрэгжүүлж орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ” нэршлээр орж батлагдсан.	100%
32.	3.10.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг,	-	Хэрэгжүүлсэн ажлын тоо	7	10	Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 оны гуравдугаар дугаар улирлын байдлаар зохион байгуулсан дараах томоохон арга хэмжээнүүдэд оролцсон баг тамирчидад Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг өгч ажиллаа. Үүнд:	90%

	зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.					1.Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн техникийн зөвлөгөөн; 2.Цэцэрлэгийн хүүхдүүдийн Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнүүдийн техникийн зөвлөгөөн; 3.Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш, арга зүйчдийг чадавхжуулах сургалт; 4.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш, арга зүйчдэд зориулсан чадавхжуулах сургалт; 5.Хөгжөөн дэмжигчдийн сургалт; 6.”Улаанбаатар лиг” волейболын тэмцээний техникийн зөвлөгөөн; 7.”Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийн техникийн зөвлөгөөн 8. Япон улсын Токио хотноо болох “Азийн өсвөрийн залуучуудын спорт солилцооны наадам - 2024” арга хэмжээнд 23 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцсон нийт 480 багийн 1160 багш, арга зүйч, тамирчдад Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.9 дэх заалт, Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хэм хэмжээг танилцуулж, мэдээллээр хангаж ажилласан.	
33.	3.11.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хэрэгжүүлсэн ажлын тоо	10	10	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 6 ўйл ажиллагаа бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөө баталж хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан бөгөөд “Харилцан хүндэтгэе” нэг сарын аянд нэгдэж 6 ажил, арга хэмжээ зохион байгуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2024 оны эхний хагас жилд зохион байгуулсан “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейбол, уран сайхны гимнастикийн тэмцээнийг зохион байгуулах хүрээнд спортын турээслэх 3 гэрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал,	70%

						орчны цэвэрлэгээ, эрүүл ахуйн чиглэлээр 2 заалт тусгаж, гэрээ дүгнэсэн протоколоор хааж ажилласан.	
34.	3.12.Биеийн тамир, спортын чиглэлээр шинээр боловсруулах, шинэчлэх шаардлагатай стандарт, нормд санал өгөх, сурталчлан хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	-	Сурталчилж ажилласан ажлын тоо, хүртээмж	0	4 ажил, 200 байгуул лагын ажилтан, албан хаагч, иргэдэд мэдээлэл хүргэсэн байна.	<p>Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд мөрдөгдөж буй 19 стандарт болон хотын хэмжээнд батлагдсан 52 стандартыг 2024 оны 3-р улирлын байдлаар зохион байгуулсан 3 сургалтын хөтөлбөрт тусган Хотын стандарт хяналтын газар, Монголын Хөнгөн атлетикийн холбоотой хамтран танилцуулж 423 байгууллагын 1230 хүнийг мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>Хан-Ул дүүргийн 8, 21, 23, 24-р хороодыг хамарсан 1535 га талбайд “27-р нэгж хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголын төсөлд спортын барилга, байгууламжийг шинээр төлөвлөж тусгуулахаар, 2024 оныг “Тохижилт, бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл хотод улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй спортын барилга, байгууламжийн явцад хамтран хяналт тавьж ажиллах талаар Хотын стандарт, хяналтын газарт албан бичгээр санал хүргүүлж, хяналт тавьж, норм, стандартын дагуу хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөн туслах ажлыг хамтран хэрэгжүүлэхээр болсон.</p>	90%
35.	3.13.Шинээр баригдаж буй спортын барилга байгууламжийг стандартын дагуу гүйцэтгэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж зөвлөн туслах ажилд оролцно.	-	Хамтран оролцсон зөвлөн туслах ажлын тоо	-	6	<p>2024 оныг “Тохижилт, бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл хотод улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй спортын барилга, байгууламжийн явцын танилцуулгыг бэлтгэн Хотын стандарт, хяналтын газарт албан бичгээр хүргүүлж, хяналт тавьж, норм, стандартын дагуу хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөн туслах ажлыг хамтран хэрэгжүүлэхээр болсон.</p> <p>Дээрх ажлын хүрээнд Налайх дүүрэгт баригдаж дууссан спорт цогцолбор, Баянхшуу дэд төвд баригдаж байгаа спорт цогцолборт холбогдох байгууллагуудын хамт газар дээр нь очиж танилцан зөвлөмж өгч ажиллаа. Баянзүрх, Багахангай, Налайх, Баянхшуу дэд төвийн барилгын ажлын явцад хяналт тавьж, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалт</p>	50%

						тус бүрээр биелэлтийг нэгтгэн дээд шатны байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна.	
Zорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:	-	Хэрэгжилтийн хувь	100	100		Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/154 дүгээр захирамжаар баталсан 12 үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр 15 ажил бүхий төлөвлөгөө гарган ажиллаж 2024 оны гуравдугаар дугаар улирлын байдлаар 80 хувийн хэрэгжилттэй байна.	75%
36.	4.1.Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг шаардлагын дагуу хангаж ажиллана.	-	Журмын шаардлагыг хангаж ажилласан байна.	4	8	Нийслэлийн Биеийн тамир, спортын 2024 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг 11 ажил, арга хэмжээтэйгээр баталж 2024 оны гуравдугаар улирлын байдлаар 50 хувьтай үргэлжилж байна. Энэ хүрээнд: Байгууллагын 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах 59, 70 жил хадгалах 2, түр хадгалах 43 нийт 101 хадгаламжийн нэгжээр байгууллагын архивд баяжилт хийсэн. Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын шаардлагын дагуу шинэчилж архивын өрөөний хадгалалтын нөхцөл шаардлагыг хангаж галын болон хамгаалалтын дохиол байршуулж, зориулалтын галын хор 2 байршуулж, архивын өрөөний цэвэрлэгээг ажлын 3 өдөр тогтмол хийж хэвшсэн. 2023 онд үүсэж хөтлөгдсөн үндсэн үйл ажиллагааны А/79, хүний нөөцийн чиглэлээр Б/29 тушаал гарсныг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ERP системийн arch.ulaanbaatar.mn дэд системд оруулж, акт үйлдэж Нийслэлийн Архивын газарт хүлээлгэн өгсэн.	70%
37.	4.2.Байгууллагын хэмжээнд дотоод хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Дотоод хяналт шалгалт хийсэн ажлын тоо	2	4	Байгууллагын хэмжээнд дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг 14 ажил, арга хэмжээтэйгээр 2024 оны 01 дүгээр сарын 30-нд баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж 2024 оны эхний хагас жилд болон 08 дугаар сард дотоод хяналт шалгалтыг хийж НЗДТГ-ын ХШҮ-ний газарт хүргүүлж ажилласан.	50%
	4.3.Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын	-	Төлөвлөгөөний	100	100	Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт байнгын үйл ажиллагаатай 5 зөвлөл байна. Үүнд: Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах төлөвлөгөөг 6 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр 2024	

	байнгын үйл ажиллагаатай хороо, комисс, зөвлөлүүд тус бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.		хэрэгжилтийн хувь			оны 01 дүгээр сарын 20-нд батлан хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/26 дугаар тушаалаар эд хөрөнгийн тооллого явуулах тушаалаар тооллогыг явуулж 41 нэр төрлийн 7,005,840.2 төгрөг бүхий актлах эргэлтийн хөрөнгийг гаргасан. ✓ Байгууллагын ёс зүйн дэд хорооны зөвлөл нь 3 гишүүнтэй, 11 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө батлан хэрэгжилтийн тайланг хагас жилээр тайлагнан ажилласан. Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол ирээгүй байна. ✓ Даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлөөр 2024 онд 11 ажил, үйлчилгээг хэлэлцүүлэхээр баталж 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 6 ажлыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна. ✓ Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын гэр бүлийн дунд 4 төрөлт “Аав, Ээж, Би” тэмцээнийг зохион байгуулсан. ✓ Залуучуудын зөвлөлөөс гаргасан саналын дагуу “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийн 5 км зайд 12-17 насны хүүхдүүдийг 2024 оны 05 дугаар сарын 23, 24-ны өдрүүдэд үнэ төлбөргүй бүртгэсэн.	90%
39.	4.4.Байгууллагын албан хаагчдыг мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх дунд болон богино хугацааны сургалтуудад хамруулна.	-	Хамрагдсан албан хаагчдын тоо	3	3	Удирдлагын академийн төрийн албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 3 албан хаагчийг хамруулж, зардлыг улсын төсвөөс шийдвэрлүүлсэн. Ахлах түшмэлийн багц сургалтад нэг албан хаагчийг хамруулахаар НЗДТГ-т хүсэлт хүргүүлж 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн суралцахаар болсон.	100%
40.	4.5.Байгууллагын албан хаагчдыг Монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт,	-	Хэрэгжүүлсэн ажлын тоо	25	28	Байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг 28 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр туссан бөгөөд 31 сургалтад давхардсан тоогоор 100 гаруй албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	90%

	ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангаж ажиллана.						2024 оны төсөвт сургалтын зардал батлагдаагүй тул албан хаагчдыг бие даан монгол бичиг судлахыг чиглэл болгосон.	
41.	4.6."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан ажлын тоо	2	2	Oйн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 2010 оны 63 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 оны хаврын мод тарих арга хэмжээнд нэгдэж 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Баянгол цэцэрлэгт хүрээлэнд 10 хайлаас мод тарьж, Баянгол цэцэрлэгт хүрээлэнгийн хамт олонд арчлах, хамгаалах ажлыг шилжүүлж өгсөн.	50%	
	Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт:	-	Сайжруулсан ажлын тоо	0	1	Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхээр иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авахаар хуваарь баталж 2024 оны гуравдугаар улирлын байдлаар 8 иргэний 5 хүсэлтийг шийдвэрлэсэн бол иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг 3 хоног 3 цаг 5 минут болж өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хоногоор бууруулж ажилласан байна.	85%	
42.	5.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн программ /erp.ulaanbaatar.mn/-ын дэд системүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандaa үргэлжлүүлэн ашиглана.	-	Байгууллагын хэмжээнд ашигласан дэд системийн тоо	11	14	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийн /erp.ulaanbaatar.mn/-ын дараах дэд системүүдийг өдөр бүр болон тухай бүр нь үйл ажиллагаандаа бүрэн ашиглан ажиллаж байна. Үнд: 1)Хурлын заал захиалгын систем; 2)Хүний нөөцийн удирдлага; 3)Тогтоол шийдвэр; 4)Утасны жагсаалт; 5)Цаг бүртгэл; 6)Ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар; 7)Судалгаа; 8)Тайлан судалгаа; 9)Өргөдөл гомдол; 10)Төрийн үйлчилгээ; 11)Онлайн бизнес төв; 12)Унааны захиалгын систем; 13)Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төв; 14) Edoc зэрэг болно.	100%	
	5.2.Иргэдийг хүлээж авах хуваарь гарган, санал хүсэлтийг цаг		Шийдвэрлэсэн ажлын тоо	15	18	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлагууд 2024 онд иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авч уулзаж, асуудлыг нь тухай бүр		

43.	тухайд нь шийдвэрлэж ажиллана.	-				шийдвэрлэхээр хуваарь гарган ажиллаж 2024 оны 3 дугаар улиралд 8 иргэнийг хүлээн авч 5 хүсэлтийг шийдвэрлэсэн.	70%
44.	5.3.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдолын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	4 хоног 18 цаг	9 хоног	Биеийн тамир, спортын чиглэлээр иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдолыг 17 эх үүсвэрээр хүлээн авах зохицуулалтын дагуу 2024 оны гуравдугаар улирлын байдлаар 14 өргөдөл, гомдол ирснийг шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох ажилтанд шилжүүлж, тухай бүр удирдлагад танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, 7 иргэний хариуг албан тоотоор өгч шийдвэрлэлтийн дундаж 3 хоног 3 цаг 5 минут байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад шийдвэрлэлтийн хугацаа 2 хоногоор буурсан үзүүлэлттэй байна.	100%
45.	5.4.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем дэх edoc.ulaanbaatar.mn системийн ашиглалтыг сайжруулан албан бичгийн шийдвэрлэлтийг хангаж ажиллана.	-	Албан бичгийн шийдвэрлэлтийн хувь	98	99	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн программ (edoc.ulaanbaatar.mn) систем буюу цахим хаягаар 2024 оны гуравдугаар улирлын байдлаар 252 албан бичиг ирсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж 98%-тай байна. Бусад байгууллага, аж ахуй нэгжид 204 албан бичгийг бүртгэж хүргүүлсэн. Ирсэн албан бичгийг өдөрт нь хүлээн авч удирдлага, хэлтэс, албан хаагчдад хүргүүлж шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.	90%
46.	5.5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын чиг үүргийн хүрээний мэдээллийг олон нийтэд ил тод хүргэж ажиллана.	-	Байршуулсан мэдээллийн тоо	68	72	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж зайлшгүй байрших 72 мэдээ, мэдээллийг sport.ub.gov.mn цахим хуудсанд бүрэн байршуулж олон нийтэд хүргэсэн.	100%

47.	5.7. Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж үр дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллана.	-	Хурлаар хэлэлцүүлсэн ажлын тоо	2	4	Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар цэцэрлэг, ЕБС-ийн биеийн тамирын багш нарт зориулсан сургалт, “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээн, “Автомашингүй өдөр-2024” нэгдсэн арга хэмжээ зэрэг 5 арга хэмжээ, уралдаан тэмцээнд оролцсон 412 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг нэгтгэж байна.	70%
48.	5.8. Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын зарим үйлчилгээг цахимд шилжүүлэх чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулна.	-	Цахимд шилжүүлсэн үйлчилгээний төрлийн тоо	5	4	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу байгууллагын <a href="mailto:www.it@sport.ub.gov.mn">www.it@sport.ub.gov.mn</a> цахим хуудсаар гуравдугаар улирлын байдлаар зохион байгуулсан биеийн тамир, спортын 41-н ажил, үйлчилгээний 55 мэдээг байршуулж 6719 хүнд, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар пэйж хуудсанд 300 мэдээлэл байршуулж 29885 хүнд хүргэж, 16214 дагагчтай болсон. 5811 удаа шэйрлэсэн үр дүнтэй гарч шинээр 67 рийлс хийж оруулсан байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг 1000 удаа хувь хүн, албан байгууллагатай цахим шуудангаар солилцсон.	100%
49.	5.9. Байгууллагын чиг үүрэгт хамаарах Хотын хөгжлийн индексийн холбогдох үзүүлэлтийн тоон мэдээллийг цуглуулах, нэгтгэх, мэдээлэх тогтолцоог бий болгох, суурь үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна.	-	Төлөвлөгөөний хэрэгжилт	0	100	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь Хотын хөгжлийн “Спортын хүртээмж” буюу 53 индексийн үзүүлэлтэд хамрагдаж 2024 онд индексийг сайжруулах хийгдэх ажлын төлөвлөгөөг 12 сараар тус тусд нь төлөвлөж 2024 оны 05 дугаар сарын 20-нд Бодлогын судалгаа, шинжилгээний төвд хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай үргэлжилж байна.	50%

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 2 зорилго 10 зорилт 49 ажил, арга хэмжээтэйгээр баталж 2024 оны 3 дугаар улирлын байдлаар төлөвлөсөн 49 ажил, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж хувьтай 85%-тай үргэлжилж байна. Төлөвлөгөөт ажлаас 100% -17, 90% -17, 70% -10, 50% - 4, 30% -1 тус тус хэрэгжүүлж ажиллахдаа улсын төсвөөс 73.473.000(далан гурван сая дөрвөн зуун далан гурван

мянган) төгрөг, нийслэлийн төсвөөс 751.248.604(долоон зуун тавин нэгэн сая хоёр зуун дөчин найман мянга зургаан зуун дөрвөн) төгрөгийг зарцуулсан байна.

ТАНИЛЦСАН:  
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
ГАЗРЫН ДАРГА

Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.СҮНЖИДМАА

